



ӨВӨРХАНГЛЫ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 27 өдөр

Дугаар 1/87

Хужирт сум

Өрхийн мэдээллийн сангийн  
судалгаа зохион байгуулах ажлын  
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн “Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааг зохион байгуулах тухай” А/88 дугаар тушаал, Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн “Аргачлал шинэчлэн батлах тухай” А/16-А/04 дүгээр хамтарсан тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын хэмжээнд “Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох хосолмол аргачлал”-аар нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн мэдээллийг шинэчлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Дэмбэрэл (Засаг даргын орлогч)

Гишүүд: Т.Энхжаргал (Хөдөлмөрийн хариуцсан мэргэжилтэн)

Б.Пагамдулам (1 дүгээр багийн Засаг дарга)

С.Самдан (2 дугаар багийн Засаг дарга)

Т.Даваадорж (3 дугаар багийн Засаг дарга)

Д.Мягмарсүрэн (4 дугаар багийн Засаг дарга)

Ц.Лхамроолом (5 дугаар багийн Засаг дарга)

Ц.Амгалан (6 дугаар багийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга: Ё.Даариймаа (Халамж хариуцсан мэргэжилтэн)

2. Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааг 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийг дуустал хугацаанд холбогдох чиглэл, аргачлалын дагуу үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Б.Дэмбэрэл),